

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLIV (543)

Улаанбаатар

2020

### НИЙСЛЭЛХҮҮГИЙН АСУУХ ӨГҮҮЛБЭРИЙН ЭВДРЭЛ: “ЦААШ НЬ ЯРИХ УУ, ЯАХ УУ?”

Ж.Лувсандорж

“Нийслэлхүү” гуай залуу насандаа говийн малчин айлд туслахаар очоод “ат шилрүүлж” ард олныхоо инээдэм болж байсан удаатай билээ. Одоо түүний хөвүүд охид өсөж үржиж “хээрийн галуу нисэн үл хүрэх газраас эрдмийг өвөрлөн ирсний” тул улс орныхоо засаг төр, яам тамганд түшлэгт сандалд сууцгаасан бөгөөд сэнтийд заларсан нь ч бий. Хуульч, өмгөөлөгч, зохиолч, сэтгүүлч, эрхэм гишүүн болсон нь ч цөөнгүй. Тэд уг нь монгол боловч үг хэл нь нэг л биш, юу хэлэх гээд юу хэлээд байна даа гэмээр байдалд орчихлоо. Нийслэлхүүгийн үг одоо инээдэм биш ханиадам болж эхэлснийг монголчууд эрхбиш анзаарах болов уу?

- Цааш нь ярих уу, яах вэ? л гэж асуудаг юм аа, манай монгол хэлтэн. Гэтэл цааш нь ярих уу, яах уу? гээд бүр томхон хурал цуглаан дээр үг хэлж байна шүү! Хэлний дутагдалд орсон хүн аж. Өнөөгийн Монголын хэвлэл мэдээллийн материалыаас зарим тийм эвгүй жишээг үзүүльье:

- Та буцаад ерөнхийлөгч, ерөнхий сайд болбол яах вэ? гэхийг “та буцаад Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болбол яах уу?” гэж бичсэн байхыг үзлээ.
- Ийм хүн ерөнхийлөгч болох юм бол та яах вэ? гэхийг “ийм хүн ерөнхийлөгч болохын бол яах уу” гэж эрхэм гишүүн асан хүн бичжээ.
- Зээлээ төлсөн ахмадууд юу бodoх вэ? гэхийг “зээлээ төлсөн ахмадууд юу бodoх уу” гэсэн байх юм.
- Найз нь чамд яаж туслах уу? гэж Ц.Балдорж хэлсэн (Ш.Гүрбазар). Ц.Балдорж гуай хэрэв тэгж хэлсэн бол “чамд яаж туслах вэ?” гэж л хэлэх хүн байсан даа!
- Хаана хэнд хандах вэ? гэхийг “хаана хэнд хандах уу?”
- Сургалт хаана хэзээ болох вэ? гэхийг “сургалт хаана хэзээ болох уу?”
- Нэгий нь ав гэвэл алий нь авах вэ? гэхийг “нэгийг нь ав гэвэл алийг нь авах уу”
- Өсвөр насныхан хараад юу бodoх вэ? гэхийг “өсвөр насныхан хараад юу бodoх уу?” гэх зэргээр ярьж хэвлэлд нийтэлдэг болов.
- “Эрүүл мэнд, боловсролын салбараа яаж хөгжүүлэх үү, ард түмнийхээ амьдралыг хэрхэн дээшлүүлэх үү, төр засаг нь хэрхэн онцгой хариуцлагатай ажиллах уу зэргээр асуудлуудаа оновчтой шийдэж чадвал Монгол Улсад өөрчлөлт авчирна” гэж монголын нэг эрхэм хүн бичсэн байна. Энэ хүн монгол хэлэнд “яаж хөгжүүлэх вэ?”, “хэрхэн дээшлүүлэх вэ?”, “хэрхэн хариуцлагатай ажиллах вэ?” гэж хэлэх бичих ёстой гэдгийг мэдэхгүй л яваа юм байна л даа. Өөр юу гэх вэ дээ.

Та бидний эх хэл ингэж муудаж байна. Дотроосоо эвдэрч байна. Энэ бичвэрийг үзэгч, уншигч эрхмүүд ийм алдсыг засаж залруулах сан гэж эрхбиш бодож байгаад итгэнэ. Ингээд одоо би энэ маягийн алдааг засах нэг хялбар аргыг бяцхан хичээл болгон заая.

Монгол хэлний дүрэм: Монгол хэлний асуух өгүүлбэрийн (Interrogative sentence) эцэст асуух сул үг орно. Асуух сул үг (Interrogative particles) гэдэг нь: 1) “бэ /вэ?, 2) уу /үү (юу /юү)?” ийм хоёр зүйл болно.

1) “бэ /вэ?” гэдгий нь асуух төлөөний үг бүхий өгүүлбэрт хэлж бичнэ. 2) “уу /үү (юу /юү)?” гэдгий нь асуух төлөөний үг байхгүй өгүүлбэрт хэлж бичнэ.

2) Асуух төлөөний үг (Interrogative pronoun) гэдэг нь: хэн, юу, хаана (хаа, хаашаа, хаагуур), хэзээ, хэдийд, хэрхэн, аль, ямар, яах (яаж, яагаад, явал, ясхийгээд, яахлаар, яахад, яасан, яадаг) – эдгээр асуух төлөөний үгс бүх хувилбараар (хэний юуны, хэнд юунд, хэнээс юунаас, хэнээр юугаар, хэнтэй юутай, хэн рүү, юу руу гэх мэт) болно.

Шилрэх гэгч үгийн тухай жич тэмдэглэл: Энэ бичвэрийн эхэнд “ат шилрэх” гэгч монгол малчны хэлц гарсан. Ат гэдэг нь агталсан тэмээний нэр. Шилрэх гэдэг нь ингэ ботголох, үнээ тугаллах болоход зарим залуу ингэ ба үнээ ижил сүргээсээ салж эзгүй газар зайллан явах. Хээлтэй ингэ, үнээнээс өөр амьтны тухайд хэлж болохгүй үг. Тийм учраас ат шилрэх гэж гэж хэлж болохгүй. Нийслэлхүү тэгж хэлээд олны инээдэм болж гардаг. Шилрэх гэдгийн утгыг шилжүүлж жирэмсэн эмэгтэйн тухайд хэлж болох л юм. Хэрэв тэгж хэлбэл тэр эмэгтэйд дургүйцэх, ёжлох егөөдөх санаатай хэлц болчихно. Тэгтэл харин одоо нийслэлийн идэвхтэн бичигч, “уран өгүүлэгч нар” тэр шилрэх гэгч үгийг бүрмөсөн ойлгохгүй болж: явах, ирэх, тэнүүчлэх, зугтах гэх мэт үйл үгээр эндүүрдэг болсон байна. Тийм алдсын хэдэн жишээ үзүүлж сануулга болгоё.

- Хуучин жил хулширч, шинэ жил шилрэх цаг ирлээ (П.Ядамдорж). “Хуучин жил холширч, шинэ жил шилжирч” гэдгийг энэ хүн буруу уншсан бололтой.
- Сэнгэнэтэл шилрээд эхнэрээ гомдоодог сэтгэлд гамгүй эрчүүд бий. Энэ зохиолч шилрэх гэдгийг явалдах гэж ухаарсан бололтой.
- Өнөөдөр хайртай хань, хөөрхөн маматайгаа заавал гадуур гарч зугаалаад шилрээд аваарай. Шилрэх гэдгийг зугаалах гэж ойлгожээ.
- Хуралдаа суухгүй хэд хоногоор шилрээд явчихдаг гишүүд ч бий. Шилрэх гэдгийг тэнүүчлэх, зугаалах гэж ойлгодог бололтой.
- Манай нутагт зун шилэрч хөх ногооны униар хөшиглөн (Гүррагчаагийн Лхагва). Одоо бүр дөрвөн улирал шилэрдэг болох нь ээ! Сүүлчийн энэ өгүүлбэрийг би нэг монгол оюутнаас асууж үзлээ. “Шил шиг гялалзсан зун байсан байх” гэж тэр хэлэв. Шилрэх гэдэг үг нийслэлхүүгийн хэлэнд учир утгаа нэгэнт алдаж этгээд үг болон хувирчээ. Энэ мэтээр эвдэрсэн баримт маш олон байна. Цааш нь ярих уу, яах вэ? Монгол хэл бичгийнхээ сургалтыг өөд нь татахгүй бол болохоо байсан биш үү.